



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 16 өдөр


Дугаар А/529

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дахь хэсгийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дуут сумын Цагаан бургас багийн нутаг дэвсгэрт байрлах Нэвт рашаан, амралтын газрын барилга шатахад ажилласан тээвэр, ажиллах хүчний зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийг баталж зарцуулсугай.
2. Зардалд зарцуулагдах 5,000,000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

8400 01:3045
Zah A/529 Kh